

**Product Data Sheet**

Edition: 22/12/2009

Identification no:

02 05 01 09 002 0 000004

Sika® MultiSeal

# Sika® MultiSeal

**Битуман тууз****Бүтээгдэхүүний  
тодорхойлолт**

Нэг талдаа хөнгөн цагаан цаасаар бүрсэн, өөрөө наалддаг битуман битүүмжлэгч тууз.

**Хэрэглээ:**

Усны нэвчилтээс хамгаалах битүүмчлэгчийг барилгын дараах орчинд хэрэглэнэ:

- Төмөр хавтан болон бүх төрлийн дээвэрт
- Барилгын хагаралд
- Битум суурьтай болон бусад төрлийн дээврийн хучлагад

**Бүтээгдэхүүний шинж  
чанар ба давуу талууд**

- Хэрэглэхэд маш хялбар
- Эдийн засгийн үр өгөөжтэй
- Олон төрлийн гадаргуу дээр наалдах чадвартай
- Цаг уурын нөхцөлд тэсвэртэй
- Өөрөө наалддаг
- Хэт ягаан туяаны хамгаалалттай
- Битумд тэсвэртэй
- Дээрээс нь давхар түрхлэг түрхэх боломжтой
- Температурын багатай орчинд хэрэглэх боломжтой

**Бүтээгдэхүүний мэдээллийн хуудас****Хэлбэр****Харагдах байдал / Өнгө**

Хоёр өнгөний сонголттой:

- Дээд тал нь: хөнгөн цагаан цаасан дээр саарал, бор хүрэн
- Доод тал нь: хуулардаг хуулгатай, өөрөө наалддаг хар битум тууз



## Сав баглаа боодол

Туузны урт	Туузны өргөн	Хайрцаган дахь хэмжээ
3 м	100 мм	12
3 м	200 мм	6
3 м	225 мм	6
10 м	50 мм	6
10 м	75 мм	4
10 м	100 мм	3
10 м	150 мм	2
10 м	200 мм	3
10 м	225 мм	2
10 м	300 мм	1
10 м	450 мм	1
10 м	600 мм	1

### Хадгалалт

**Хадгалах нөхцөл / хугацаа** Сав баглаа боодол онгойж, цоороогүй тохиолдолд үйлдвэрлэсэн өдрөөс 72 сарын хугацаанд хуурай сэрүүн нөхцөлд +5°C+25°C орчинд хадгална. Нарны шууд тусгалаас хамгаал

### Техникийн үзүүлэлт

**Химийн суурь** резинээр сайжруулсан битуман тууз  
**Нягт** 1.2 – 1,5 гр/см<sup>3</sup>  
**Үе давхрагын зузаан** ~ 1,2 мм (~ 0,05 мм зузаантай хөнгөн цагаан цаас багтсан болно)  
**Галд тэсвэртэй байдал** DIN 4102 стандартын В2д нийцсэн  
**Ашиглалтын температур** -20°C + 70°C

### Механик, физик шинж чанарууд

**Суналтын бат бэх** Уртаашаа: ~ 3,6 кг/см<sup>2</sup>  
Хөндлөн: ~ 3,5 кг/см<sup>2</sup>

**Суналтын тасралт** 25 – 50%

### Системийн мэдээлэл

#### Гүйцэтгэлийн нөхцөлүүд

##### Гадаргуун чанар

- Гадаргуу нь бат бэх байж, урвалд орж болзошгүй гадаргуун бүх төрлийн бохирдлоос ангид, цэвэр, хуурай байх шаардлагатай.

##### Гадаргуун бэлтгэл

- Гадаргуу дээрх сул эд хэсгүүд, тосолгооны материал, цементийн сүү, будаг, зэв болон наалдах чадвар муутай бусад түрхлэг зэргийг гадаргуу бэлтгэлийн гар аргаар болон механик багажийн тусламжтайгаар бэлдэнэ.

- Метал, хуванцар г.м гадаргууг уусгагчаар (Sika® Cleaner-205 г.м) сайтар цэвэрлэнэ.
- Нүхжилт ихтэй гадаргуунд (бетон, шавардлага г.м) наалдах чадварыг битум суурь түрхлэгээр (Inertol-1 г.м) сайжруулж өгнө. Суурь түрхлэгийг түрхсэнээс хойш хамгийн багадаа 1 цаг хатааж өгөх шаардлагатай.

## Хэрэглэх нөхцөлүүд / Хязгаарлалтууд

<b>Гадаргуун температур</b>	Хамгийн багадаа +5°C / хамгийн ихдээ +40°C +10°C –ээс бага температуртай орчинд гүйцэтгэл хийхээс өмнө тууз болон гадаргууг халааж өгөх шаардлагатай. Халуунаар үлээгч багажуудыг ашигла.
<b>Орчны температур</b>	Хамгийн багадаа +5°C / хамгийн ихдээ +40°C +10°C –ээс бага температуртай орчинд гүйцэтгэл хийхээс өмнө тууз болон гадаргууг халааж өгөх шаардлагатай. Халуунаар үлээгч багажуудыг ашигла.
<b>Гадаргуун чийгшлийн Хэмжээ</b>	Гадаргуу хуурай байх шаардлагатай

## Хэрэглээний зааварчилгаа

<b>Хэрэглэх аргачлал / Багажууд</b>	<p>Туузаа шаардлагатай уртын дагуу тайран авч, хамгаалалтын хуулгыг хуулан аваад гадаргуу дээр тохиромжит даралтад өнхрүүшээр жигд дарж нааж өгнө.</p> <p>Залгаа хэсгүүдийг хооронд нь хамгийн багадаа 50 мм-ийн хэмжээтэй давхарлан нааж шаардлагатай.</p> <p>Анхаар: Гүйцэтгэлийн үед гадаргуутай наалдах чадварыг нэмэгдүүлэхийн тулд туузыг халуун үлээгч багажаар халааж өгөх боломжтой.</p>
<b>Анхаарах зүйлс / хязгаарлалтууд</b>	<p>Усны даралттай заадаст хэрэглэж болохгүй. Усны даралттай орчныг хэрэглэх ус чийгний хамгаалалттай бүтээгдэхүүний талаар манай Техникийн Хэлтэсээс зөвлөгөө авна уу.</p> <p>+25°C-ээс дээш халуун орчинд таазанд хэрэглэхэд тохиромжгүй.</p> <p>Туузны найрлага дахь битумээс шалтгаалан зарим төрлийн байгалийн чулуу, хуванцар болон түрхлэгүүдийн өнгө хувирч болзошгүй.</p> <p>Нүхжилт ихтэй гадаргууд хэрэглэсэн тохиолдолд туузны дотор талд усны шүүрэл үүсэх боломжтой.</p>
<b>Дүгнэлт</b>	Энэхүү Техникийн зааварчилгаанд дурьдагдсан үзүүлэлтүүд бүгд лабораторын туршилтанд үндэслэгдсэн болно. Бодит үзүүлэлтүүд нь тодорхой нөхцөл байдлаас шалтгаалан өөр өөр байж болохыг анхаарна уу.
<b>Дотоодын хязгаарлалт</b>	Тухайн улс орны дотоодын хууль тогтоомжоос хамааран уг бүтээгдэхүүний гүйцэтгэл ялгаатай хийгдэх боломжтой. Иймээс манай Техникийн хэлтэст холбогдож зөвлөгөө авах боломжтой.

## Эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны мэдээлэл

Бүтээгдэхүүнийг зөв хэрэглэх, хадгалах, химийн бодисын хаягдлыг зайлуулах зэрэг Аюулгүй ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг мөн физик, экологи, хортой байдал болон бусад аюулгүй ажиллагаатай холбоотой мэдээллийг цогцоор агуулсан Материалын Аюулгүй ажиллагааны мэдээллийн хуудаснаас авах бүрэн боломжтой.

### Хууль эрх зүйн мэдээлэл

Энэхүү маягтан дээр ерөнхий мэдээлэл нь Sika бүтээгдэхүүнийг хэрэглэх, хадгалах, ердийн нөхцөлд боловсруулалт хийх зааврыг агуулсан ба эдгээр мэдээлэл нь Sika бүтээгдэхүүний талаар олж авсан мэдээлэл болон ойлголт дээрээ үндэслэсэн болно. Тиймээс зарим төрлийн бүтээгдэхүүн нь хэрэглэх талбай, талбайн тухайн үеийн нөхцөлд зэрэгтэй уялдан харилцан адилгүй нөлөөлөл үзүүлдэг тул энэхүү мэдээллийн хуудас нь тухайн бүтээгдэхүүний баталгааны хуудас болж чадахгүй гэдгийг онцлон тэмдэглэж байна. Sika бүтээгдэхүүнийг өгөгдсөн зааврын дагуу хэрэглэсний улмаас үүсэж болзошгүй аливаа нэгэн асуудалтай холбоотой хууль эрх зүйн хариуцлага хүлээх боломжгүй юм. Бүтээгдэхүүний захиалгыг өнөөгийн хүлээн зөвшөөрөгдсөн нөхцөл болон хүргэлтийн шаардлагын дагуу хүлээн авах ба бүтээгдхүүнтэй холбоотой өөрчлөлтийг хэрэглэгч нь үйлдвэрлэгчид албан ёсоор хүсэлт гаргасны үндсэн дээр авч болно.

Sika Services AG  
Tueffenwies 16  
CH-8048 Zurich  
Switzerland

Phone: +41 44 436 40 40  
Telefax: +41 44 436 46 86  
[www.sika.com](http://www.sika.com)

**Sika**®